



МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,  
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2018.12.06 № 05/10267.  
танай 2018.11.20 ны № 05/5588-Г



Хувийн ашиг сонирхлын урьдчилсан  
мэдүүлэг хянасан тухай

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН  
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Р.МЭРГЭН ТАНАА

Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын төмөр замын зурвас газар, байгаль орчин хариуцсан мэргэжилтнээр томилогдохоор нэр дэвшсэн Батсайханы Батзориг, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын авто замын салбарын бодлого, хөтөлбөр, төслийн хяналт-шинжилгээ, дотоод аудит хариуцсан ахлах мэргэжилтнээр томилогдохоор нэр дэвшсэн Базарын Гантөмөр нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигчид нь тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлэх, түүнчлэн хуулийн 23 дугаар зүйлийн 23.3, Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т зааснаар тухайн албан тушаалд томилогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгээ гаргах үүргийг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН  
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА  
ЭРХЭЛСЭН КОМИССАР

  
Х.ХАШБААТАР  


0010981